

## **“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТҮНШЛЭЛИЙН КОМПАКТ: ХҮН ХУДАЛДААЛАХААС ХҮҮХДИЙГ ХАМГААЛАХ НЬ” ТӨСӨЛ**

**“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, насанд хүрээгүй хохирогчид нөхөн олговор олгох талаар олон улсын сайн туршлагыг судалж, өөрийн улсад хэрэгжүүлэх зохистой арга, хэлбэрийг тодорхойлох, санал, зөвлөмж боловсруулах”**

### **ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**

Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департамент хооронд байгуулсан “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт” Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төсөл дөрөв дэх жилдээ хэрэгжиж байна.

Төсөл нь Монгол Улсад хүүхэд худалдаалсан гэмт этгээдийг хуулийн дагуу яллаж, зохих ял шийтгэлийг оногдуулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын чадавхыг бэхжүүлж, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд учирсан гэмтэл, хохирлыг нөхөн сэргээхэд чиглэсэн цогц үйлчилгээ үзүүлж, улмаар Монгол Улс даяар хүүхэд худалдаалах гэмт хэргийн бүх төрлөөс урьдчилсан сэргийлэх зорилготой.

Энэхүү төслийг Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Улсын ерөнхий прокурорын газар, Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба ерөнхий удирдлагаар хангаж, “Дэлхийн зөн Монгол” олон улсын байгууллага, “Азийн сан” олон улсын байгууллага хамтран хэрэгжүүлж байна.

#### **Зөвлөх үйлчилгээний зорилго:**

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, ялангуяа насанд хүрээгүй хүнд нөхөн олговор олгох талаар олон улсын сайн туршлага, хууль эрх зүйн орчин, бүтэц тогтолцоо, загварыг судалж, өөрийн улсад хэрэгжүүлэх зохистой арга, хэлбэрүүдийг тодорхойлж, санал зөвлөмж боловсруулна.

#### **Ажлын даалгавар:**

1. Хүн худалдаалах (бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг хууль бусаар авах) гэмт хэргийн хохирогч, ялангуяа насанд хүрээгүй хохирогчид нөхөн олговор олгож буй хууль эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах;

2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор олгож буй шат дараалал, хариуцах байгууллага, тогтолцоо, бүрдүүлэх баримт бичиг болон түүнд зарцуулах хугацаа, арга зам, насанд хүрээгүй хохирогчид хамаарах тусгай зохицуулалттай эсэх талаар нарийвчлан судалж, харьцуулалт хийх. Ингэхдээ дараах шалгуурын дагуу 3-аас доошгүй улсыг харьцуулах:

2.1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын чиглэлээр сайн ажилладаг, эрх зүйн орчинтой, хохирогчид олгох нөхөн олговрын систем нь тогтворжсон, туршлага болохуйц хэрэгжилттэй;

2.2. Хүн худалдаалах, гэмт хэргийн хохирогчид нөхөн олговор өгөх чиглэлээр шинээр хуульдаа тусган ажиллаж байгаа;

2.3. Манай улстай эрх зүйн системтэй.

3. Палермогийн протоколд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болон насанд хүрээгүй хохирогчид нөхөн олговор олгох талаарх зохицуулалт, манай улсын хуульд хэрхэн тусгагдсан байдал болон хэрэгжих боломжид дүн шинжилгээ хийх;

4. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болон насанд хүрээгүй хохирогчид нөхөн олговор олгох талаар олон улсын сайн туршлага, загвар, олон улсын стандартад үндэслэн өөрийн улсад хэрэгжүүлэх боломжит арга хэлбэр, зохицуулалтын загварыг тодорхойлсон санал, зөвлөмж боловсруулах;

5. Судалгааны үр дүнгийн тайланг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын дунд нэгдсэн хэлэлцүүлэг зохион байгуулах, тэднээс гарсан саналыг тусгах;

6. Захиалагч байгууллага болон хэлэлцүүлгээс гаргасан санал, зөвлөмжийг тусган эцсийн тайланг оролцогч талуудад хүлээлгэн өгснөөр дуусгавар болно.

#### **Зөвлөх үйлчилгээний хугацаа:**

Зөвлөх багийн ажил гүйцэтгэх хугацаа нь 2024 оны 03 дугаар сараас 05 дугаар сарыг дуустал үргэлжилнэ.

Эхлэлийн тайлан: 2024 оны 04-р сарын 10

Эцсийн тайлан: 2024 оны 05-р сарын 20

#### **Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлага:**

- Зөвлөх үйлчилгээний үндсэн гүйцэтгэгч нь хуулийн этгээд байх;
- Мэргэшсэн хүний нөөцтэй байх: эрх зүйч (эрүүгийн эрх зүй, гэмт хэргийн хохирогч хүүхдэд өмгөөллийн үйлчилгээг дагнан үзүүлж байсан туршлагатай бол давуу тал болно), нийгмийн халамж, хамгааллын магистр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай хүний нөөцтэй байх;
- Ур чадвар: Мэдээлэл нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх чадвартай, англи хэлний ярианы болон бичгийн чадвартай байх;

#### **Бүрдүүлэх материал:**

- ✓ Байгууллагын танилцуулга (сүүлийн 3 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон судалгааны жагсаалт)
- ✓ Гишүүдийн танилцуулга
- ✓ Үйл ажиллагааны төлөвлөгөө, үнийн саналыг хамт ирүүлнэ.